



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/326

Булган сум

**Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV дүгээр хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2023 оны XIV/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн музейн барилгын засварын зураг төсөл боловсруулах ажлыг 20,000,000 (хорин сая) төгрөгөөр “Грэйнт маунт консалтинг” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Грэйнт маунт консалтинг” ХХК (Г.Билгүүн)-д үүрэг болгосугай.

3. Аймгийн музейн барилгын засварын зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Дээрх ажлын санхүүжилтийг тухайн төсөл арга хэмжээний батлагдсан төсвөөс гэрээнд заасан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010315